**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД,**
**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД**
**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2018 оны 02 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар А/027, А/047, А/35

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны "Үндэсний хөтөлбөр батлах тухай" 270 дугаар тогтоолын 2, 3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийг 2018-2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралт ёсоор батлалсугай.

2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газар /С.Тунгалагтамир/-т, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Ерөнхий боловсролын бодлогын газар /Д.Эрдэнэчимэг/-т, Сургуулийн өмнөх боловсролын бодлогын газар /Б.Үүлэнсолонго/-т, Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн газар /Д.Ганцэцэг/-т, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /О.Алтансүх/-т, бүх шатны Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Г.Өнөрбаяр/, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Л.Цэдэвсүрэн/, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Ганцэцэг/ нарт тус тус үүрэг болгосугай.

4. Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, дүнг нэгтгэн жил бүрийн 12 дугаар сард багтаан танилцуулж байхыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /О.Алтансүх/-т үүрэг болгосугай.

| | | |
|---|---|---|
| ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД | БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД | ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД |
| С.ЧИНЗОРИГ | Ц.ЦОГЗОЛМАА | Д.САРАНГЭРЭЛ |

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын 2018 оны 02 сарын 07-ний өдрийн A/027 / A/047 / A/34 тоот хамтарсан тушаалын хавсралт

# ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ /2018-2019/

| № | *Хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа* | *Бүтээгдэхүүн/Хэрэгжүүлэх арга хэмжээ* | *Шалгуур үзүүлэлт* | *Хариуцах байгууллага* | *Хамтрах байгууллага* | *Хугацаа* | *Төсөв* |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 1. Хүүхдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангасан хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлнэ.** | | | | | | | |
| *1.1 Хүүхдэд ээлтэй эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, хүүхдийн сэргийлж болох өвчлөл, эндэгдлийг бууруулах чиглэлээр* | | | | | | | |
| 1.1.1 | Эх, нярай болон 5 хүртэлх насны хүүхдийн нэн шаардлагатай эрүүл мэндийн багц тусламжийн хамралтыг нэмэгдүүлэх | 1. Анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлдэг өрхийн эмч нарт зориулсан сургалт зохион байгуулах. | Хүүхдийн эсэн мэнд амьдрахуйтай холбоотой сургалтад хамрагдсан өрхийн эмчийн эзлэх хувь | ЭМЯ[1] | НҮБХС[2], ДЭМБ[3] | Жил бүр | ЭМЯ |
| | | 2. Эх нярай болон бага насны хүүхдийн эрүүл мэндийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээний жагсаалтыг боловсруулж батлуулах. | Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний жагсаалт гарсан тушаал, шийдвэр | | | | |
| | | 3. Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийг шинэчлэн боловсруулж, хэрэглээг нэмэгдүүлэх. | Шинэчлэн боловсруулсан дэвтэр, түүний хэрэглээ | ЭМЯ[4] | НҮБХС, ДЭМБ | 2018-2019 | ЭМЯ |

[1] Эрүүл мэндийн яам
[2] Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүүхдийн сан
[3] Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
[4] Эрүүл мэндийн яам

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 4. Эцэг эхчүүд 0-5 насны хүүхдийнхээ хөгжлийг хянахад туслах гарын авлага боловсруулах, эцэг эхчүүдийг сургалтад хамруулах. | Баталсан гарын авлага, сургалтад хамрагдсан эцэг эхийн тоо | ЭМЯ | БСШУСЯ[5], ХНХЯ[6], ГБХЗХГ[7] | 2018-2019 | ЭМЯ |
| 1.1.2 | Товлолт болон сайн дурын дархлаажуулалтад 5 хүртэлх насны хүүхдийн хамралтыг нэмэгдүүлэх | 1.Сурталчилгааны материалуудыг боловсруулж, хэвлэж, түгээх.<br>2.Олон нийтэд чиглэсэн нөлөөллийн аян зохион байгуулах. | Товлолт вакцинд хамрагдалт 100%д хүрсэн байна. | ЭМЯ | МҮОНРТ, НҮБХС, ДЭМБ | Жил бүр | ЭМЯ |
| 1.1.3 | Хүүхдийн сэргийлж болох өвчлөл, эндэгдэлд (хатгалгаа, сүрьеэ, суулгалт, осол гэмтэл зэрэг) нөлөөлөх хүчин зүйлсийг бууруулах үйл ажиллагааг аймаг, нийслэлийн Засаг даргын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлэх. | 1. Хүүхдийн сэргийлж болох өвчлөл, эндэгдлээс урьдчилан сэргийлэх талаар сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах удирдамж, чиглэлийг орон нутагт хүргүүлэх.<br>2. Мэдээллийн хуудас, гарын авлага боловсруулж, иргэдэд тараах. | Хүүхдийн сэргийлж болох өвчлөл эндэгдэл бууралтын хувь | ЭМЯ | Бүх шатны Засаг дарга, түүний харьяа орон нутгийн байгууллагууд | Жил бүр | ЭМЯ |
| | | 3. Хүүхдийг осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр эцэг эхчүүд, багш сурган хүмүүжүүлэгч, олон нийтэд чиглэсэн нөлөөлөл, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах. | | ЭМЯ | ГБХЗХГ, ЗЦГ, Бүх шатны Засаг дарга, түүний харьяа орон нутгийн байгууллагууд | 2018-2019 | ГБХЗХГ |
| 1.1.4 | Хүүхэд бүрийг бодисын солилцооны эмгэг, хөгжлийн | 1. Хүүхдийн эрүүл мэндийн товлолт урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах эрх зүйн орчныг бий болгох. | Гарсан тушаал, шийдвэр, журам | ЭМЯ, ХНХЯ, БСШУСЯ | ХБХЭМБНХК[8] | 2018 | ЭМЯ |

[5] Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
[6] Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
[7] Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар
[8] Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хоцрогдол, бэрхшээлийн эрт илрүүлэлт, үзлэг оношилгоонд тогтмол хугацаанд хамруулах. | 2. Хүүхдийн хөгжлийн үнэлгээ, хоцрогдол, бэрхшээлийг илрүүлэх аргачлал батлуулж, хэрэгжүүлэх. | Батлагдсан аргачлал | | | | |
| | | 3. 0-16 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий комиссын үйл ажиллагааг тогтмолжуулах. | - Салбар комиссын хурлаар орсон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо,<br>-Хөгжлийн дэмжлэгт хамрагдсан хүүхдийн тоо | ХБХЭМБНХК | Аймаг, дүүргийн салбар комисс | 2018-2019 | ХНХЯ |
| 1.1.5 | Хөдөөгийн болон орлого багатай өрхийн хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах арга хэмжээ авч, нэн шаардлагатай амин дэмээр хангах, амин дэм түгээх явцад хоол тэжээлийн зөвлөгөө өгөх ажлыг хавсран явуулах. | 1. Зорилтот бүлэгт чиглэсэн эрүүл мэндийн үйлчилгээний хөтөлбөр боловсруулах. | Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан зорилтот бүлгийн хүүхдийн тоо | ЭМЯ | Бүх шатны Засаг дарга, түүний харьяа орон нутгийн байгууллагууд | 2018 | ЭМЯ |
| | | 2. Эмч, эцэг эхчүүдэд зориулсан зөвлөмж, гарын авлага гаргаж түгээх. | Зөвлөмж, гарын авлагын тоо | | | | |
| 1.1.6 | Хүүхдийн шүдний цоорол, өвчлөлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлж, хүүхдийн шүдний эмчилгээний | 1. Хүүхдийн шүдний өвчлөлийг хянах тогтолцоо бий болгох. | Хүүхдийн шүдний өвчлөлийг хянах зохицуулалт хийсэн шийдвэр | ЭМЯ | - | 2018 | ЭМЯ |
| | | 2. Хүүхдийн шүдний эмчилгээний төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх боломжийг судалж хэрэгжүүлэх. | -Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх шийдвэр<br>-Зохион | ЭМЯ, ЭМНДЕГ[9] | - | 2018 | Эрүүл мэндийн даатгалын сан |

[9] Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх боломжийг судалж хэрэгжүүлэх. | 3. Эцэг, эхчүүд, хүүхдүүдэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах. | байгуулсан ажлын тоо | ЭМЯ | БСШУСЯ | 2018 | ЭМЯ |
| 1.1.7 | Цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоол, хүнсний бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн аюулгүй байдалд хяналт тавих ажлыг эцэг, эхийн оролцоотой зохион байгуулах. | 1. Цэцэрлэг, сургуулийн хоолны үйлчилгээ, хүнсний аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг сайжруулах. | Хууль, журамд орсон өөрчлөлт, шийдвэр | ЭМЯ, БСШУСЯ | | 2018 оноос тогтмол | БСШУСЯ |
| | | 2. Цэцэрлэг, сургуулийн хоол, хүнсний бүтээгдэхүүний худалдаа, үйлчилгээний чанар, эрүүл ахуй, аюулгүй байдалд хяналт, шалгалт хийх. | -Эцэг эхийн оролцоотой хийсэн хяналт шалгалтын тоо, -Зөвлөмжийн хэрэгжилт | БСШУСЯ, ЭМЯ, МХЕГ | Сургууль, цэцэрлэгийн Эцэг эхийн зөвлөл | | |
| | | 3. Цэцэрлэг, сургуулийн хүүхдийн насны онцлогт тохирсон хоол шим тэжээлийн багц, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулж түгээх. | Мэдээллийн багц, сурах бичиг, гарын авлага боловсруулж, түгээсэн тоо | БСШУСЯ, ЭМЯ | - | | |
| 1.1.8 | Хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хүнсний бүтээгдэхүүний худалдаа, үйлчилгээг сургууль, цэцэрлэгийн орчинд хориглох. | 1. Сургууль, цэцэрлэгийн орчинд хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хориглосон хүнсний бүтээгдэхүүний хэрэглээнд хяналт тавих. | -Хяналт шалгалтын тоо, -Зөвлөмжийн хэрэгжилт | БСШУСЯ, МХЕГ | ЭМЯ, Аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ[10], Сургууль, цэцэрлэгийн Эцэг эхийн зөвлөл | 2018 оноос тогтмол | БСШУСЯ, МХЕГ |
| | | 2.Эцэг эхчүүд, олон нийтийн хяналтын тогтолцоо бий болгох, хэрэгжүүлэх | Хяналт хийсэн дүгнэлт, баримт | | | | |
| | | 3. “Хүүхдэд зориулав” хүнс, хөнгөн үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг зохион байгуулах. | Зохион байгуулсан үзэсгэлэн худалдааны тоо, | ХХААХҮЯ[11] | ААНБ-ууд[12] | 2018 он | ХХААХҮЯ |

[10] Засаг даргын Тамгын газар
[11] Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
[12] Аж ахуйн нэгж, байгууллагууд

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | үр дүн | | | | |
| | | 4.“Хүүхдэд зориулсан бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх боломж, арга зам”, “Шар лууванги йн шүүсний хүүхдийн өсөлт хөгжилд нөлөөлөх байдал”-ын сэдвүүдээр судалгааны ажил хийх. | Хийсэн судалгааны ажил, судалгааны үр дүнг ашигласан байдал | ХХААХҮЯ | ЭМЯ, БСШУСЯ, Монгол ногоо төсөл | 2018-2019 он | ХХААХҮЯ |
| | | 5. Хүүхдэд зориулсан хоолны цэс зохиож нэвтрүүлэх талаар нийтийн хоолны газруудад уриалга, зөвлөмж гаргаж үйлчилгээний байгууллагуудад хүргүүлэх, зөвлөмжийг хэрэгжүүлэх. | Уриалга, зөвлөмж, түүний хэрэгжилт | ХХААХҮЯ | МХЕГ | 2018 он | ХХААХҮЯ |
| *1.2. Өсвөр үеийнхэнд ээлтэй эрүүл мэндийн тусламж , үйлчилгээг өргөжүүлж, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр* | | | | | | | |
| 1.2.1 | Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт эрүүл мэндийн хичээлийг тусгах. | 1.Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт эрүүл мэндийн хичээлийг оруулах шийдвэр гаргах. | Баталсан шийдвэр | БСШУСЯ | ЭМЯ, МХЕГ | 2018 он | БСШУСЯ |
| 1.2.2 | Өсвөр үеийнхэнд зориулсан эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг дэмжиж, эрүүл амьдралын хэв маягт төлөвшүүлэх. | 1. Эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр өсвөр үеийнхэнд зориулсан нэвтрүүлэг, контент гаргах. | Нэвтрүүлэг контентын тоо | ЭМЯ | БСШУСЯ, ЭМЯ | 2018 оноос жил бүр | БСШУСЯ, ЭМЯ, ГБХЗХГ |
| | | 2. Өсвөр үеийнхний оролцоог хангасан сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах. | Сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд хамрагдсан өсвөр үеийнхний тоо | | | | |
| 1.2.3 | Нөхөн үржихүйн болон сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавхийг аймаг, | 1. Хүүхэд, өсвөр үеийнхэнд нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр сургалтын хөтөлбөр, боловсруулж, хэрэгжүүлэх. | Боловсруулсан хөтөлбөр | ЭМЯ | СЭМҮТ[13], МҮОРТ[14], | 2018 он | ЭМЯ |

[13] Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
[14] Монголын үндэсний олон нийтийн радио телевиз

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дүүргийн түвшинд бэхжүүлэх. | 2. Гэр бүлийн боловсрол олгох хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх. | Гэр бүлийн боловсрол олгох тусгай хөтөлбөр | ХНХЯ, ГБХЗХГ | БСШУСЯ | 2018 он | ГБХЗХГ |
| | | 3. Өсвөр үеийн кабинетийн эмч нарыг нөхөн үржихүйн болон сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавхыг бэхжүүлэх. | Тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавх аймаг, дүүргийн түвшинд бэхэжсэн байдал. | ЭМЯ | Аймгийн ЭМГ[15], дүүргийн ЭМТ[16] | 2018 он | ГБХЗХГ |
| | | 4. Өсвөр үеийн кабинетийн эмч нарт зориулсан сургалт зохион байгуулах, гарын авлага гаргаж түгээх. | | | | | |
| 1.2.4 | Ерөнхий боловсролын сургуульд эмч, сэтгэл зүйч ажиллуулж, хүүхэд, өсвөр үеийнхний хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх. | 1.Ерөнхий боловсролын сургуульд эмч, сэтгэл зүйч ажиллуулах талаар судалж, шийдвэрлэх. | Эмч, сэтгэл зүйчтэй сургуулийн эзлэх хувь | БСШУСЯ | ЭМЯ | 2018-2019 | БСШУСЯ |
| 1.2.5 | Багш, эмч, нийгмийн ажилтан, сайн дураар ажиллах оюутан, залуучуудыг нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүлийн болон бэлгийн боловсрол олгох сургагч багшаар бэлтгэх. | 1. Багш, эмч, нийгмийн ажилтан, сайн дураар ажиллах оюутан, залуучуудыг нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүлийн болон бэлгийн боловсрол олгох сургагч багшаар бэлтгэх. | -Бэлтгэсэн сургагч багшийн тоо<br>-Хүрч ажилласан хүүхдийн тоо | ЭМЯ, ГБХЗХГ | БСШУСЯ, Аймаг, нийслэлийн боловсролын газар | 2018-2019 | ЭМЯ |

[15] Аймгийн эрүүл мэндийн газар
[16] Дүүргийн эрүүл мэндийн төв

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.6 | Дэлгэцийн донтолт, архи, тамхи, мансууруулах бодисын хор нөлөө, хүчирхийлэл, дарамт, шахалт, эрсдэлд өртөхөөс сэргийлэх талаар хүүхэд, өсвөр үеийнхэнд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах. | 1. Өргөн нэвтрүүлэг, цахим орчинд тамхи, согтууруулах ундаа, мансууруулах бодис, хүчирхийлэл, садар самуун сурталчилсан контентыг илрүүлж, насны ангиллын тэмдэг тавих, хандалтыг хязгаарлах, эрх зүйн орчныг сайжруулах. | Хууль эрх зүйн зохицуулалт | ХЗДХЯ[17] | ЦЕГ[18], ХХЗХ[19] | 2018-2019 | ХЗДХЯ |
| | | 2. Дэлгэцийн донтолт, архи, тамхи, мансууруулах бодисын хор нөлөө, хүчирхийлэл, дарамт, шахалт, эрсдэлд өртөхөөс сэргийлэх, хамгаалах талаар хүүхэд, өсвөр үеийнхэнд зориулсан сургалт, сурталчилгаа, нөлөөллийн компанит ажил өрнүүлэх. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | ХЗДХЯ, БСШУСЯ, ГБХЗХГ | ЦЕГ[20], ХХЗХ[21], МСЭН | 2018-2019 | ГБХЗХГ |
| | | 3.Телевизүүд өөрийн хөтөлбөрөөр гаргахгүй контентын хэм хэмжээг тогтоож, нийтэд ил тод зарлаж, мөрдөх. | ТВ бүр өөрийн Хөтөлбөрт мөрдөх дүрэмтэй болсон байх | ХХЗХ | МСЭН, МТХ[22] | 2018 | ХХЗХ |
| | | 4. Сургууль бүр цахим болон архи, тамхи, мансууруулах бодисын донтолтод хүүхэд, өсвөр үеийнхэн өртөж байгаа эсэх талаар судалгаа авч, хянах тогтолцоо бий болгох. | Судалгааны тайлан | БСШУСЯ | ХХЗХ, ЦЕГ, ГБХЗХГ | Жил бүр | БСШУСЯ |
| 1.2.7 | Өсвөр үеийнхний эрүүл мэндийн үзүүлэлтийг гаргаж мэдээллийн сан бүрдүүлэх. | 1. Өсвөр үеийнхний эрүүл мэндийн үзүүлэлт батлах.<br>2. Мэдээллийн сан бий болгох. | Мэдээллийн сангийн ашиглалт | ЭМЯ | БСШУСЯ, НЭМҮТ[23] | 2018 оноос тогтмол | ЭМЯ |

[17] Хууль зүй, дотоод хэргийн яам
[18] Цагдаагийн ерөнхий газар
[19] Харилцаа холбооны зохицуулах хороо
[20] Цагдаагийн ерөнхий газар
[21] Харилцаа холбооны зохицуулах хороо
[22] Монголын телевизүүдийн холбоо
[23] Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв

| 1.3. Эцэг, эх асран хамгаалагч, олон нийтэд хүүхдийг асрах, хүмүүжүүлэх мэдлэг, хандлага төлөвшүүлэх чиглэлээр | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.3.1 | Хүүхдэд зонхилон тохиолдох өвчин, эмгэгээс сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах. | 1.Мэдээлэл, сурталчилгааны материал бэлтгэж түгээх. | Мэдээлэл, сурталчилгааны ажлын тоо | ЭМЯ | БСШУСЯ, НЭМҮТ, Хэвлэл мэдээллийн байгууллагууд | 2018 оноос тогтмол | ЭМЯ |
| | | 2.Хүүхдийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх нэвтрүүлэг контент гаргах. | | | | | |
| 1.3.2 | Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуулийг сурталчлах, хүүхдийг эхийн сүүгээр хооллохыг дэмжихэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааг өргөжүүлэх. | 1. Сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах. | Сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаанд хамрагдсан эхчүүдийн тоо | ЭМЯ | НЭМҮТ, Хэвлэл мэдээллийн байгууллагууд | Жилдээ | ЭМЯ |
| 1.3.3 | Хүүхдийг насны онцлогт нь тохируулан асрах, хүмүүжүүлэх мэдлэг, хандлагыг эцэг, эх, асран хамгаалагч нарт төлөвшүүлэх ажлыг хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоотойгоор зохион байгуулах. | 1. Хүүхдийг насны онцлогт нь тохируулан асрах, хүмүүжүүлэх мэдлэг, хандлагыг дээшлүүлэх эцэг, эх, асран хамгаалагч нарт зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах. | -Хүүхдийн насны онцлогоор гаргасан сургалтын хөтөлбөр,<br>-Сургалтад хамрагдсан эцэг эхийн тоо | ГБХЗХГ<br>ЭМЯ | ХНХЯ, Хэвлэл мэдээллийн байгууллагууд | Жилдээ | БСШУСЯ ГБХЗХГ |
| | | 2. Хүүхдийг насны онцлогт тохируулан асрах, хүмүүжүүлэх, мэдлэг, хандлагыг эцэг, эх, асран хамгаалагч нарт төлөвшүүлэх, олон нийтийг эерэг мэдээллээр хангах, соён гэгээрүүлэх мэдээлэл, нэвтрүүлэг бэлтгэн хүргэх. | Олон нийтэд хүргэсэн мэдээллийн тоо | МҮОНРТ[24], ХХЗХ[25], ГБХЗХГ | МСЭН | Жилдээ | ГБХЗХГ |

[24] Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз
[25] Харилцаа, холбооны зохицуулах хороо

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.3.4 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, гэр бүлийн гишүүдийг хүүхдээ асрах, сэргээн засах, хөгжүүлэх чиглэлийн сургалтад үе шаттай хамруулах. | 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эхчүүдэд зориулсан гарын авлага гаргаж, сургалт зохион байгуулах. | Гарын авлага, сургалтад хамрагдсан хүний тоо | ХБХЭМБНХК | Аймаг, дүүргийн салбар комисс | 2018-2019 | ХНХЯ |
| | | 2. Хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж, сонгосон аймаг, дүүрэгт, турших. | Хөтөлбөрт хамрагдсан хүүхдийн тоо | ХБХЭМБНХК | Сонгогдсон аймаг дүүргийн ГБХЗХГ/хэлтэс | 2018 | Жайка ОУБ |
| *1.4. Хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагааг эрчимжүүлж, нийгмийн хариуцлагыг төлөвшүүлэх чиглэлээр* | | | | | | | |
| 1.4.1 | Боловсролын болон хүүхдийн асрамж, халамжийн байгууллагад тавигдах эрүүл ахуйн болон үйлчилгээний стандартыг шинэчлэн баталж мөрдүүлэх. | 1. Боловсролын байгууллагад тавигдах орчны болон эрүүл ахуйн үйлчилгээний стандартыг боловсруулах. | Шинэчлэн баталсан стандарт | БСШУСЯ, ЭМЯ | МХЕГ | 2018-2019 | БСШУСЯ, ЭМЯ |
| | | 2. Дотуур байрны стандартыг шинэчлэн боловсруулж, баталж мөрдүүлэх. | Шинэчлэн баталсан стандарт | БСШУСЯ | МХЕГ | 2018- 2019 | БСШУСЯ |
| | | 3. Сургалт хүмүүжлийн байгууллагын барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах норм, дүрмийг шинэчлэн баталж, мөрдүүлэх. | Шинэчлэн баталсан стандарт | БХБЯ | МХЕГ | 2018- 2019 | БСШУСЯ |
| | | 4. Хүүхдийн байгууллагын дотоод орчны агаарт химийн хорт бодис, нянгийн үзүүлэлтийг тогтоосон стандарт шинээр боловсруулах. | Баталсан стандарт | ЭМЯ | БСШУСЯ, ГБХЗХГ, МХЕГ | 2018- 2019 | БСШУСЯ, ЭМЯ |
| | | 5.Өдөр өнжүүлэх төвийн үйлчилгээний стандарт боловсруулж, баталж, мөрдүүлэх. | Шинэчлэн баталсан стандарт | БСШУСЯ | МХЕГ | 2018- 2019 | БСШУСЯ |
| | | 6.Үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр мөрдөгдөж буй журам, | Шинэчлэн баталсан журам | БСШУСЯ | МХЕГ | 2018- 2019 | БСШУСЯ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | заавврыг шинэчилж мөрдүүлэх. | | | | | |
| 1.4.2 | Хүүхдийн хувцас, тоглоом, хичээлийн хэрэгсэл, сургалтын тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, худалдаанд тавих хяналтыг иргэдийн оролцоотойгоор сайжруулах. | 1. Иргэдээс гомдол, мэдээлэл авах, түүний мөрөөр ажиллах сувгийг бий болгох. | Хяналт шалгалтын тоо | МХЕГ | БСШУСЯ, ХНХЯ, ГБХЗХГ | 2018 оноос тогтмол | БСШУСЯ, ГБХЗХГ, МХЕГ |
| | | 2. Хүүхдийн тоглоом, хичээлийн хэрэгслийн аюулгүй байдлын үзүүлэлтийг тодорхойлох, лабораторын чадавхыг нэмэгдүүлэх. | Лабораторын чадавхи | МХЕГ | | 2019 он | |
| 1.4.3 | Хүүхдийг ахуйн болон зам тээврийн осол, гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх талаар эцэг, эх, асран хамгаалагч, багш нарын хариуцлагыг нэмэгдүүлэх сурталчилгааны ажлыг өрнүүлж, санамж, сэрэмжлүүлэг түгээх. | 1. Зам тээврийн осол ихээр гардаг, гарч болзошгүй замтай ойр байрлах эрсдэл бүхий сургуулиудыг “Сургуулийн бүс-техникийн ерөнхий шаардлага” стандартын дагуу тохижуулах. | Хүүхдийн осол гэмтлийн бууралтын хувь | ЗТЯ[26], БСШУСЯ, ЗЦГ | Аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ | 2018 оноос тогтмол | ЦЕГ, Аймаг, нийслэлийн ЗДТГ |
| | | 2. Ахуйн хүрээнд гарч байгаа эрсдэлийг бууруулах талаар эцэг, эхчүүд, хүүхдэд зориулсан санамж, сэрэмжлүүлгийг хэвлэж, түгээх. | Боловсруулсан материалыг хүлээн авсан иргэдийн тоо | ЭМЯ, ГБХЗХГ | Хэвлэл мэдээллийн байгууллагууд | 2018 он | ЭМЯ |
| | | 3. Цахилгааны аюулгүй байдал хангагдаагүй, эрсдэлтэй өрхийг илрүүлж, хүүхэд бэртэхээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах. | Урьдчилан сэргийлсэн өрхийн тоо | ЭХЯ[27] | Бүх шатны Засаг дарга, түүний харьяа орон нутгийн байгууллага | 2018-2019 | ЭХЯ |
| | | 4. Орон нутгийн болон хот хоорондын тээвэр, хөдөө орон нутагт хүүхдийг зохион байгуулалттай тээвэрлэх үед аюулгүй байдлыг хангах | Журам баталсан шийдвэр, хэрэгжүүлсэн байдал | ЗТЯ, ЗЦГ[28] | - | 2018 он | ЗТЯ |

[26] Зам тээврийн яам
[27] Эрчим хүчний яам
[28] Замын цагдаагийн газар

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | журам гаргаж мөрдүүлэх. | | | | | |
| | | 5. Бага насны хүүхдийг аюулгүй тээвэрлэх дүрэм, журмыг мөрдүүлж, зориулалтын суудлыг хэрэглэж хэвшүүлэх. | Зориулалтын суудлыг хэрэглээгүйгээс осол, гэмтэлд өртсөн хүүхдийн хувь | ЗЦГ | - | 2018 он | ЗЦГ |
| 1.4.4 | Агаарын бохирдлын улмаас хүүхдийн эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахад чиглэсэн арга хэмжээг хууль тогтоомжид тусган хэрэгжүүлэх. | 1.Хууль, тогтоомжид тусгаж, хэрэгжилтийг хангах. | Хуулийн хэрэгжилтийн хувь | ЭМЯ, БОАЖЯ[29] | НЗДТГ НҮБХС | 2018 он | ЭМЯ, БОАЖЯ |
| 1.4.4 | | 2. Агаарын бохирдлын хүүхдийн эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх. | Зохион байгуулсан арга хэмжээ | ЭМЯ, БОАЖЯ | НЗДТГ, НҮБХС | 2018-2019 | ЭМЯ, БОАЖЯ |
| 1.4.5 | Эрүүл мэндийн болон боловсролын байгууллагын магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтэд “Хүүхдэд ээлтэй эмнэлэг”, “Эрүүл мэндийг дэмжигч сургууль”-ийн үзүүлэлтийг тусгах. | 1.Эрүүл мэндийн болон боловсролын байгууллагын магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтэд “Хүүхдэд ээлтэй эмнэлэг”, “Эрүүл мэндийг дэмжигч сургууль”-ийн үзүүлэлтийг тусгаж, шинэчлэн батлуулах. | Шинэчлэн баталсан шалгуур үзүүлэлт | ЭМЯ | НЭҮТ | 2018 он | ЭМЯ |
| 1.4.5 | | 2. Шалгуур үзүүлэлтийн дагуу “Хүүхдэд ээлтэй эмнэлэг”, “Эрүүл мэндийг дэмжигч сургууль”-ийг шалгаруулах. | Шалгуур хангасан байгууллагын тоо | ЭМЯ, БСШУСЯ | НЭҮТ | Жил бүр | ЭМЯ |
| **Зорилт 2. Хүүхэд бүрийг хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлж, хүүхдийн авьяас, чадварыг нээн хөгжүүлнэ.** | | | | | | | |
| *2.1 Хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, эцэг эх, олон нийтийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр:* | | | | | | | |

[29] Байгаль орчин, аялал жуулчлалын яам

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.1 | Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагаанд үнэлгээ хийж, зөвлөмж гаргах, гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх. | 1. Бодлого хөтөлбөрт үнэлгээ хийж, зөвлөмж гаргах, зөвлөмжийн дагуу бага насны хүүхдийн хөгжлийг дэмжсэн бодлогыг шинэчилж, боловсруулах. | -Үнэлгээний тайлан,<br>-Шинэчлэн батлагдсан бодлого үйл ажиллагааг баталсан шийдвэр | БСШУСЯ | ХНХЯ, ГБХЗХГ | 2018-2019 | БСШУСЯ |
| 2.1.2 | Бага насны хүүхдийн хөгжлийг гэр бүлийн орчинд дэмжих чиглэлээр бий болсон сайн туршлагыг түгээн дэлгэрүүлж, эцэг эхийн чадавхыг нэмэгдүүлэхэд хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоог сайжруулах. | 1. Хүүхдийн хүмүүжилд сөрөг нөлөө үзүүлэх контентыг цацахгүй байх, зөв төлөвшил, ёс суртахуунтай Монгол хүүхдийг төлөвшүүлэхэд чиглэсэн контент бэлтгэж нэвтрүүлэх талаар хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж, ажиллах. | хэвлэл мэдээллийн байгууллагуудаар мэдээлсэн тоо | ГБХЗХГ, ХХЗХ | МТХ, МСНЭ | 2018 он | ГБХЗХГ |
| | | 2.Сургуулийн өмнөх боловсролын хичээлийн агуулга, хөтөлбөрийн талаар эцэг, эхчүүдэд танилцуулах, хүүхдээ хөгжүүлэх талаар эцэг эхчүүдэд сургалт зохион байгуулах. | Сургалтад хамрагдсан эцэг, эхчүүдийн тоо | БСШУСЯ | - | 2018 он | БСШУСЯ |
| 2.1.3 | Хүүхдийн хөгжил, төлөвшил, хүмүүжилд сөрөг нөлөө үзүүлж болох хүчин зүйлсийг тогтоох, түүнээс урьдчилан сэргийлэх талаар эцэг, эх, асран хамгаалагч, багш | 1.Хүүхдийн хөгжил, төлөвшил, хүмүүжилд сөрөг нөлөө үзүүлж болох хүчин зүйлсийг тодорхойлох судалгаа хийж, зөвлөмж гаргах. | Судалгааны тайлан, зөвлөмжийн хэрэгжилт | ГБХЗХГ, ЦЕГ | БСШУСЯ | 2018-2019 он | ГБХЗХГ |
| | | 2. Судалгааны зөвлөмжид үндэслэн хүүхэд, эцэг эхчүүдэд зориулсан төрөлжсөн сургалт, зохион байгуулах. | Сургалтад хамрагдсан хүний тоо | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нарын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх. | 3. Нийслэл, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа баар, зочид буудлын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх, энэ төрлийн үйлчилгээ эрхлэгчдийн хүүхэд хамгааллын талаарх ойлголт хандлагыг нэмэгдүүлэх. | -Хийсэн хяналт, шалгалт<br>-зохион байгуулсан үйл ажиллагаа | ХЗДХЯ[30], ЦЕГ[31], ГБХЗХГ | МХЕГ | 2018 | ХЗДХЯ |
| 2.1.4 | Хүүхдийг амьдрах ухаанд сургаж, харилцааны зөв хэвшилтэй, бусдыг хүндлэх, хариуцлагатай, итгэл даах чадвартай болгон төлөвшүүлэн хөгжүүлэх цогц бодлого хэрэгжүүлэх. | 1.Хүүхэд, өсвөр үеийнхний хэрэгцээнд нийцсэн чөлөөт цаг өнгөрүүлэх, шинэ төрлийн үйлчилгээ бий болгох талаар бусад орны туршлага судалж, оновчтой хувилбарыг сонгосон аймаг, дүүрэгт туршилтаар хэрэгжүүлэх. | Сайн туршлага хэрэгжүүлсэн аймаг, дүүргийн тоо | ГБХЗХГ | БСШУСЯ, ХНХЯ | 2018-2019 | ГБХЗХГ |
| | | 2.Хүүхдийн хөгжлийн үйлчилгээний нэр төрлийг тодорхойлох, хүүхдийн олон талт чадварыг нь нээн хөгжүүлэхэд чиглэсэн хөгжлийн хөтөлбөр боловсруулж, батлуулах. | -Хөтөлбөр баталсан шийдвэр,<br>-Хөгжлийн хөтөлбөрт хамрагдсан хүүхдийн хувь | ГБХЗХГ | БСШУСЯ, ХНХЯ | 2018-2019 | ГБХЗХГ |
| | | 3.Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн өргөн нэвтрүүлгээр мэдээлэл авах эрхийг хангах үүднээс хүүхэд, боловсрол, танин мэдэхүйн нэвтрүүлгийг дохионы хэл, бичгэн тайлбартай гаргах. | Нэвтрүүлгийн тоо | ХХЗХ | МҮОНТ, МТХ | 2018-2019 | ГБХЗХГ |
| 2.1.5 | Сургуулийн өмнөх насны бүх хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд бүрэн хамруулж сургуульд бэлтгэх. | 1. Сургуульд элсэхийн өмнөх бүх насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд бүрэн хамруулах арга хэмжээг зохион байгуулах. | СӨБ-д хамрагдалтын хувь | БСШУСЯ | БСШУСЯ, ХНХЯ | 2018-2019 | ГБХЗХГ |

[30] Хууль зүй, дотоод хэргийн яам
[31] Цагдаагийн ерөнхий газар

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.6 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг суурь боловсролд тэгш хамруулахад чиглэсэн цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх. | 1. Тусгай хэрэгцээт боловсролын тэнхим нээж, багш бэлтгэх. | Бэлтгэгдсэн багшийн тоо | БСШУСЯ | - | 2018-2019 | БСШУСЯ |
| | | 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тархцын судалгааг үндэсний түвшинд хийх. | Судалгааны үр дүн тайлан | БСШУСЯ | - | 2018-2019 | БСШУСЯ |
| | | 3. Дэмжлэг шаардлагатай хүүхдэд зориулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх. | Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр ажилласан хүүхдийн хувь | БСШУСЯ | - | 2018-2019 | БСШУСЯ |
| | | 4. Насан туршийн боловсролын үндэсний төвөөр дамжуулан гэрээр айлчлах зочин багш хөтөлбөр хэрэгжүүлэх, хэвтрийн, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд бичиг үсэг, бага, суурь боловсрол эзэмшүүлэх. | -Гэрийн сургалтад хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо<br>-Зочин багшийн тоо<br>-Зочин | БСШУСЯ | - | 2018-2019 | БСШУСЯ |
| 2.1.7 | Тусгай хэрэгцээт боловсролын багш бэлтгэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээнд тохирсон сургалтын хөтөлбөр, сурах бичгийг шинэчлэн боловсруулах. | 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээнд тохирсон сургалтын хөтөлбөр, сурах бичгийг шинэчлэх, хэвлэх. | -Тусгай хэрэгцээт боловсролын багшийн тоо,<br>-Сурах бичгээр хангагдсан хүүхдийн тоо | БСШУСЯ | - | 2018 оноос | БСШУСЯ |
| 2.1.8 | Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд хүүхдийн хөгжлийг дэмжих асуудлыг тусгах, уг үйлчилгээний удирдлага, зохион байгуулалт, төсөв, хяналтын | 1. Хүүхэд харах үйлчилгээг сургуулийн өмнөх боловсрол олгох хувилбарт үйлчилгээ рүү шилжүүлэх. | Хууль, тогтоомжийн өөрчлөлт | БСШУСЯ | - | 2018 он | БСШУСЯ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтолцоог оновчтой болгох | | | | | | |
| 2.1.9 | Хүүхдэд байгаль орчноо хайрлах, үндэсний өв уламжлал, соёл, ёс заншлаа мэдэх, хүндэтгэх, суралцахад чиглэсэн үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн музей, номын сан, хэвлэл мэдээлэл, соёл, урлагийн байгууллага, түүхч, эрдэмтэн, ахмад настан, алдар гавьяат хүмүүсийн оролцоотой зохион байгуулах | 1. Хүүхдэд байгаль орчноо хайрлах, үндэсний өв уламжлал, соёл, ёс заншлаа мэдэх, хүндэтгэх агуулгыг цэцэрлэг, сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгах. | Шинэчлэн баталсан сургалтын хөтөлбөр | БСШУСЯ | Аймаг, нийслэлийн ЗДТГ, цэцэрлэг сургуулиуд | 2018 | БОАЖЯ, БСШУСЯ, ГБХЗХГ |
| | | 2. Үндэсний болон орон нутгийн музей, номын сан, хэвлэл мэдээлэл, соёл, урлагийн байгууллага, түүхч, эрдэмтэн, ахмад настан, алдар гавьяат хүмүүсийг оролцуулсан уулзалт, чөлөөт ярилцлага зохион байгуулах. | Зохион байгуулагдсан арга хэмжээ, хамрагдсан хүүхдийн тоо | БСШУСЯ | Аймаг, нийслэлийн ЗДТГ, цэцэрлэг сургуулиуд | 2018 | БСШУСЯ |
| | | 3.Телевизүүдийн хүүхдэд зориулсан нэвтрүүлэгт судалгаа хийх. | Судалгааны тайлан | ГБХЗХГ, ХХЗХ | ТНХ, МСНЭ | 2018-2019 | ГБХЗХГ |
| | | 4. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийн агуулгад эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын ойлголт, ач холбогдлын талаар тусгах. | Хөтөлбөрт туссан байдал | БСШУСЯ, НДЕГ | - | 2018 | БСШУСЯ, НДЕГ |
| 2.1.10 | Гэр хороололд хүүхдийн тоглоомын талбай, чөлөөт цагийн төв байгуулах, тохижуулах, засварлах талаар санаачилга гаргаж байгаа иргэн, байгууллагыг дэмжих, олон нийтэд сурталчлах | 1. Хорооллын дунд байгаа тоглоомын талбайн аюулгүй байдалд тавих стандартыг баталж, мөрдүүлэх. | Батлагдсан стандарт | БХБЯ | ГБХЗХГ, Аймаг, нийслэлийн ЗДТГ | 2018 оноос | ГБХЗХГ |
| | | 2. Хорооллын дунд хүүхдэд зориулсан чөлөөт цагаа өнгөрүүлэх тоглоомын талбайг тохижуулах, засварлах, аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулах. | Шинээр байгуулагдсан тоглоомын талбай | Аймаг, нийслэлийн ЗДТГ | - | 2018 оноос тогмол | НЗДТГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| *2.2 Хүүхдэд чиглэсэн сургалт, хөгжүүлэх ажлын нэр төрлийг нэмэгдүүлэх, чанар хүртээмжийг сайжруулах, материаллаг баазыг бэхжүүлэх чиглэлээр:* | | | | | | | |
| 2.2.1 | Сургуулиас гадуурх сонгон, секц, дугуйлангийн үйл ажиллагаа, сургалтын чанар, хүртээмж, үнэ төлбөрийн байдалд үнэлгээ хийж, дүгнэлт гаргах. | 1. Сургууль дээрх сонгон, секц, дугуйлангийн өнөөгийн байдалд судалгаа хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах. | -Үнэлгээний тайлан, -Сайжруулах чиглэлээр авсан арга хэмжээ | БСШУСЯ | ГБХЗХГ | 2018 оноос тогтмол | БСШУСЯ ГБХЗХГ |
| | | 2. Хүүхдийг хөгжүүлэх чиглэлээр иргэд, байгууллагаас явуулж байгаа үйл ажиллагаа, үнэ төлбөрт жил бүр үнэлгээ хийж, дүгнэлт гаргах. | -Үнэлгээний тайлан, -Сайжруулах чиглэлээр авсан арга хэмжээ | ГБХЗХГ | ХОҮС | 2019 он | ГБХЗХГ |
| 2.2.2 | Хичээл, сургуулиас гадуурх сонгон, секц дугуйлангийн хүртээмж, сургалтын чанарыг сайжруулахад чиглэсэн үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх. | 1.Багш, насан туршийн боловсролын ажилтан, нийгмийн ажилтнуудад хичээл, сургуулиас гадуур зохиогдох хөгжлийн хөтөлбөрийн арга зүйн сургалт зохион байгуулах. | Сургалтад хамрагдсан багшийн тоо | БСШУСЯ | ГБХЗХГ, ХОҮС[32] | 2018-2019 | БСШУСЯ |
| | | 2. Сургууль дээрх хичээлээс гадуурх үйл ажиллагааг хүүхэд бүрт оролцох, хөгжих боломжийг бүрдүүлсэн хүртээмжтэй хэлбэрээр зохион байгуулах талаар анги удирдсан багш нарт зориулсан удирдамж, чиглэл боловсруулж хүргүүлэх. | Баталж, хүргүүлсэн удирдамж, чиглэл | БСШУСЯ | ГБХЗХГ | 2018-2019 | БСШУСЯ |
| | | 3.Анги удирдсан багш нарт зориулсан улирал тутмын сэтгүүл гаргах. | Улирал тутам сэтгүүл гаргасан байх | БСШУСЯ | ГБХЗХГ | 2018-2019 | БСШУСЯ |
| 2.2.3 | Хүүхдийн зусланд хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төслийг шалгаруулж, санхүүгийн | 1. Хүүхдийн зуслангийн хөгжлийн хөтөлбөрт санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам боловсруулж, батлуулж, хэрэгжүүлэх. | -Дэмжлэг авсан зуслангийн тоо - Зусланд амарсан хүүхдийн тоо | ХНХЯ, ГБХЗХГ | Хүүхдийн заслан | 2018 оноос тогтмол | ГБХЗХГ |

[32] Хүүхдийн оролцооны үндэсний сүлжээ

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дэмжлэг үзүүлэх боломжийг судалж хэрэгжүүлэх. | | | | | | |
| 2.2.4 | Урлаг, спортын чиглэлээр улс, олон улс, тив, дэлхийн чанартай уралдаан, тэмцээнд оролцох болзол хангасан болон амжилт гаргасан хүүхдэд дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгох эрх зүйн орчинд үнэлгээ хийж, ялгавартай байдлыг арилгах арга хэмжээ авах. | 1. Урлаг, спортын чиглэлээр улс, олон улс, тив, дэлхийн чанартай уралдаан, тэмцээнд оролцох болзол хангасан болон амжилт гаргасан хүүхдэд дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгох журмуудад үнэлгээ хийх.<br>2. Үнэлгээний дүнд үндэслэн журмуудыг шинэчлэн боловсруулж, батлуулж, хэрэгжүүлэх. | -Шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлсэн журам<br>- Дэмжлэг авсан хүүхдийн тоо | БСШУСЯ | ГБХЗХГ, | 2018 он | БСШУСЯ |
| 2.2.5 | Хүүхдийн санаачилсан шинэ бүтээлийг дэмжих, урамшуулах тогтолцоог бүрдүүлэх. | 1. Хүүхдийн санаачилсан шинэ бүтээлийг дэмжих, урамшуулах журам боловсруулж, батлуулах, хэрэгжүүлэх. | Дэмжлэг, урамшуулал хүртсэн хүүхдийн тоо | БСШУСЯ, ОӨУБЕГ[33] | ГБХЗХГ | 2018-2019 | ГБХЗХГ |
| 2.2.6 | Цахим тоглоомын газар, интернет төвүүдийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, хүүхдийн бие бялдар, оюун ухаан, сэтгэл зүй, хүмүүжилд нь сөрөг нөлөө үзүүлэх үйл ажиллагаа явуулж байгаа газар, | 1.Цахим тоглоомын газрын үйл ажиллагааг зохицуулсан журмыг шинэчилж мөрдүүлэх. | -Стандартын хэрэгжилт,<br>-Тоглоомын үйлчилгээний хяналт, шалгалтын үр дүн | ХЗДХЯ | ЦЕГ ГБХЗХГ, МХЕГ Аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ | 2018-2019 | ЦЕГ, МХЕГ |
| | | 2.Цахим, тоглоомын газар, интернэт төвүүдийн үйлчилгээ, орчны стандарт боловсруулж, батлуулах. | Батлуулсан стандарт | ХЗДХЯ | ЦЕГ, ХХЗХ НЗДТГ | 2018-2019 | ХЗДХЯ |

[33] Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төвийн үйл ажиллагааг нь зогсоох хүртэл арга хэмжээ авах. | 3.Цахим тоглоомын газар, интернет төвүүдийн үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг тогтмол зохион байгуулах. | -Зохион байгуулсан хяналт, түүний мөрөөр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа | ХЗДХЯ | ЦЕГ, ХХЗХ, МХЕГ, НЗДТГ | 2018-2019 | ХЗДХЯ |
| 2.2.7 | Зарим аймаг, дүүрэгт хүүхдийн хөгжлийн ордон, хүүхэд хамгааллын үйлчилгээний төв байгуулах, барих, өргөтгөл хийх төсөв, хөрөнгийг шийдвэрлэх | 1.Хүүхдийн хөгжлийн ордонгүй аймгуудад ордон барих төсөв хөрөнгийг улсын төсөвт тусгах. | Шинээр ашиглалтад орсон, өргөтгөл хийсэн хүүхэд, залуучуудын ордон, Хүүхэд хамгааллын төвүүдийн тоо | СЯ | ХНХЯ, Аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ | 2019 оноос | БСШУСЯ ХНХЯ |
| **Зорилт 3. Хүүхдийг сонсох, үзэл бодлыг нь хүндэтгэх нийгмийн хандлагыг төлөвшүүлж, бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцад хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх** | | | | | | | |
| *3.1. Хүүхдийн оролцоог дэмжих талаар эцэг эх, асран хамгаалагч, багш, нийгмийн ажилтны ойлголтыг нэмэгдүүлэх, хүүхдийн өөрийн удирдлагын байгууллага, клуб, бүлгийн санал, санаачилгыг дэмжих чиглэлээр:* | | | | | | | |
